



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 9/125

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-4 гудамж, 421 тоот)-д байршилтай Базарзагдаа овогтой Болдбаатар (ЗЮ:84021771)-ийн амины орон сууцны зориулалттай 150 м.кв (0,015 га) газрыг иргэн Алтангэрэл овогтой Ууганбаатар (ЗА:90052612)-т зориулалтаар нь шилжүүлж 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/209 дугаар захирамжийн Б.Болдбаатар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 00069903 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190352